



Эсээ



Эсээ гэж юу вэ

Хүн ертөнцийг танин мэдэж, ойлгож ухаарсныхаа хэрээр аливаа асуудлыг баримт дээр тулгуурлан олон талаас нь шинжлэн судлах, ажиглан эргэцүүлэх, задлан тайлбарлах, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших, томъёолон таамаглах, адилтган зүйрлэх зэрэг оюуны төрөл бүрийн үйл хийснийхээ үндсэн дээр өөрийн бодол санаагаа илэрхийлэх хамгийн нээлттэй төрөл бол эсээ юм.

- Аливаа юмсын тухай задгай сэтгэлгээ, элдэв найруулгыг чадмаг хослуулан бичдэг төрлийг эсээ гэнэ.
- Эсээ нь элдэв баримтаас бодрол бясалгал өрнүүлэн, түүний тухай оюунлаг ертөнцийг дэлгэж, чөлөөт уран тайлбар ургуулж, “би” баатрын үзэл бодлын өвөрмөц шийдлийг бүтээдэг.



- Гүн ухаан
- Шинжлэх ухаан
- Уран сайхны
- Нийтлэл найрууллын
- Утга зохиол, шүүмж эсээ
- Хөрөг эсээ



Эсээний талаар эрдэмтэн, судлаач, уран бүтээлчид тодорхойлсон нь

Профессор Д.Галбаатар: “Эсээ нь хүүрнэл /туульсын болон сэтгүүл зүй,судалгаа шинжилгээний/ зохиолын нэг зүйл. Эсээ нь уран зохиолд ямар нэг шалтгаан хийгээд асуудлын талаар хувь уран бүтээлчийн бодол, эргэцүүлэмж, таамаглалыг шингээсэн юмс үзэгдлийн мөн чанар, шалтгаан холбоо хамаарлыг заавал бүрэн буюу гүйцэд илэрхийлсэн байх албагүй бэсрэг хэмжээтэй, чөлөөт уран сэтгэмж, чөлөөт зохиомжит үргэлжилсэн үгийн зохиолын бие даасан шинэ төрөл зүйл болж хөгжжээ. ...бичлэгийн хэв маяг нь товч яруу дүрслэг шинжтэй байхаас гадна ярианы аялга, үгсийн сан, зорилгоороо ялгардаг. ...Эсээ гадаад хэлбэр, бичлэг, зохиомжийн хувьд сэтгүүл зүйн, агуулгын хувьд уран зохиолд хамруулж болохуйц бүтэцтэй”

Эрдэмтэн, зохиолч Л. Түдэв: “Тодорхой сэдвийг зохиолч хэрхэн бясалган эргэцүүлж ямар дүгнэлтэд хүрснийгээ чөлөөтэйгөөр хүүрнэн өгүүлэх богино хэлбэрийн зурвас өгүүлэл, найруулал, шүүмжийн аль алины шинж төрхийг агуулсан задгай зохиомжтой зохиол болон хэвшсэн байна”.

Профессор М.Зулькафиль” “Эсээ бичигч тал бүрээс нь нарийвчлан судалж, түүнийг эрэмбэ, дэс дараалалтай нарийн логик холбоогоор үзүүлэхийг урьтал болгодоггүй, харин сонгож авсан сэдвээ нийгмийн хурц асуудлыг хөндөхөд чиглүүлж, түүнийгээ хувийн сэтгэгдэлтэй хослуулан бодол эргэцүүллийн маягаар гаргаж хэлэхийг гол зорилгоо болгодог”.

Доктор Л. Норовсүрэн: “Төрөгдөл бичигч аливаа үйл явдал, үзэгдлийг урнаар үзүүлэхийн тулд уран яруу найруулга, ярианы хэлийг ашиглан, элдэв баримт жишээг чөлөөтэй хэрэглэдэг байна. Төрөгдлийг шинжлэх ухаан, гоо зүй, ёс суртахуун, түүхийн аль ч сэдвээр бичлээ гэсэн гүн ухааны бясалгалын аяс нэвтэрхий байдаг нь түүний гол онцлог мөн”

Эсээний үндсэн шинж



- Өгүүлэл, найруулал, нийтлэл, шүүмжийн аль алины шинжийг агуулсан тул богино хэлбэрийн эх
- Бодол бясалгал, эргэцүүлэлийн шинжтэй.
- Нэг зүйлийг олон талаас нь тайлбарлан авч үздэг.
- Баримт нотолгоог үндэс болгодог.
- Дүрслэл, ур маягийг чөлөөтэй ашигладаг.
- Зөвхөн зохиогчийн үзэл бодлын илэрхийлэл
- Дэвшүүлсэн асуудал нь нээлттэй /задгай/
- Эсээ нь загварт буюу сургалтын , загварт бус буюу чөлөөт \мэргэжлийн\ гэсэн хоёр өөр түвшинтэй.

Эсээний хэв маяг

Хүүрнэмж

Тоочимж

Тайлбарламж

Эргэцүүлэмж

Холимог

Холимог

Хоорондоо цаг хугацаа, учир зүйн
холбоотой үйл ба хэрэг явдлыг дараалан
дүрсэлж өгүүлэх зорилготой хүүрнэмж
./Narrative/

Тодорхой хүн ба юм үзэгдэл, газар орны
гадаад төрх байдал, шинж чанарыг
тодорхойлон дүрслэх зорилготой тоочимж
./Descriptive/

Ямар нэг үйл явдал, үзэгдэл юмсын талаар
шинэ мэдээлэл өгч, учир шалтгааныг
тайлбарлан таниулах зорилготой
тайлбарламж ./Expository/

Ямар нэг зүйлийн талаар бусдад
итгүүлж, үнэмшүүлэх, зүй тогтлыг батлан
дүгнэлт хийх зорилготой эргэцүүлэмж
(учирламж) ./Presuasive or argumentative/

Эсээ бичих бэлтгэх шат

1.Бичих зорилго
(Яахын тулд бичих
гэж байна вэ?)

- Зохиогч ямар нэг зүйлийн тухай уншигчдад санаа бодлоо илэрхийлэх, мэдээлэх, тайлбарлах, итгүүлэн үнэмшүүлэх зэрэг зорилгоор бичдэг.

2. Уншигчаа
тодорхойлох (Хэнд
зориулж бичих вэ?)

- Сэдэв, дэд сэдэв сонгох
- Өнгө аяс, хандлага

3. Баримт
цуглуулах (Юун
тухай бичих вэ?)

- Сэдэвтэй холбоотой сонирхолтой баримт цуглуулах
- Хэт их баримт оруулахаас зайлсхийх

4. Баримтаа
ангилах эрэмбэлэх (
Та чухам юу хэлэх
гэж байна вэ?)

- Нийтлэг шинжээр нь бүлэглэн ангилах
- Баримтаа гол ба гол бусаар ялгах
- Баримтаа учир зүйн дараалалд оруулах
- Тухайн асуудлаар хэрхэн бичих вэ ? гэдгээ тодруулах төлөвлөгөө зохиох

ЭСЭЭ БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ



Яарахгүй байх



Төөрөхгүй байх



Судалгаатай байх

ЭСЭЭ БИЧИХ ҮЕ ШАТ



Сунжрахгүй байх



Эхлэлтэй байх



Төгсгөлтэй байх

Эсээ бичих алхам

Сэдэв

- ☐ Сэдвийг ерөнхий сэдэв, тодорхой сэдэв гэж ангилдаг. Ерөнхий сэдэв нь өргөн хүрээтэй учир бичихэд хүндрэлтэй.
- ☐ Сэдвээ сонгохдоо ерөнхий биш тодорхой сэдэв сонгох
- ☐ Бичих сэдвээ сайн ойлгосон байх
- ☐ Сонгосон сэдэв чинь хүмүүст хэр хэрэгтэй вэ?

Гарчиг

- ☐ Гарчигт бүгдийг агуул. Гарчигт гол санаа агуулагдсан байхаас гадна уншигчдын сонирхол татахуйц байх .
- ☐ Сүржин гарчиг өгөхөөс зайлсхийх



Түлхүүр өгүүлбэр буюу хөтөч санаа

Уг сэдэв, асуудлын талаар зохиогч юу хэлэхийг хүсэж байгааг илтгэсэн гол санааны хураангуй илэрхийлэл юм .

- ☐ Эсээний турш хөтөч болж, чиглүүлэхээр байх
- ☐ Эсээний гол санаа туссан байх
- ☐ Хандлага, өнгө аясыг илэрхийлсэн нэг л өгүүлбэр байх
- ☐ Асуудал дэвшүүлсэн байх
- ☐ Уншигчийн анхаарлыг өөртөө хандуулан хөтөлж чадахуйц сэтгэл татам, үнэмшилтэй ,сонирхолтой байх



Эсээ бичих алхам

Эхлэл хэсэг

- Анхаарал татахаар эхлэх
- Суурь мэдээлэл өгөх
- Түлхүүр өгүүлбэрийг дэлгэрүүлсэн баримтаар эхлэх
- Бичиж буй зүйлийнхээ эсрэг санааг сонгож эхлэх
- Сэдвийнхээ чухал болохыг уншигчдад хүргэх , өвөрмөц шийдэлтэй байх
- Сонин содон хэрэг явдал, товч түүхээр эхлэх
- Өөрт болон бусдад тохиолдсон явдлаар эхлэх
- Асуултаар эхлэх
- Эшлэлээр эхлэх

Үндсэн хэсэг

Үндсэн хэсэг хамгийн чухал бөгөөд 2-4 цогцолбороор төлөвлөх . Зорилго нь эсээний гол санааг дэмжих нэмэлт санаанууд юм.


Гол санаага:

- Жишээ баримтаар дэмжих, батлах, жишээ баримтыг харьцуулах, эсрэгцүүлэх зэргээр баяжуулах
- Ажиглалт таамаглалуудыг батлах. Баримт мэдээлэлд тулгуурлан өөрийн үзэл бодол, байр сууриа баймж хандлагаар илэрхийлэх
- Үндэслэлээ батлах


Төгсгөл хэсэг

- Төгсгөл хэсэг 1 юмуу хэд хэдэн цогцолбороос бүтнэ. Санаагаа зангидах, дүгнэх хэсэг гэж үзнэ.
- Зохиогчийн бодол бүхий дүгнэлтээр төгсгөх
- Уншигчийн сонирхлыг татахаар асуултаар төгсгөх
- Таамаглал дэвшүүлж төгсгөх
- Үргэлжлэлтэй мэт төгсгөл
- Асуудал үлдээх төгсгөл

ЭСЭЭНИЙ ҮНДСЭН БҮТЭЦ



Эсээний бүтэц



Анхаарал тавьсанд баярлалаа.

